



ХОВД АЙМГИЙН ДУУТ СҮМҮН ХӨХБЭЛЧИР БАГТ ХУДАГ ГАРГАХ
АЖЛЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт/
гэрээний нэр, дугаар:

Хөвд аймгийн Дуут сумын хөхбэлчир баат худаг гараах
ажлын тендерийн баримт бичиг
ХОАОНӨГ/202001144

Ховд хот
2020 он

БАТЛАВ: ДУУТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА А.ЭНХБАЯР

**ХОВД АЙМГИЙН ДУУТ СУМЫН ХӨХБЭЛЧИР БАГТ ХУДАГ ГАРГАХ
АЖЛЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/
гэрээний нэр, дугаар:

*Ховд аймгийн Дуут сумын хөхбэлчир багт худаг гаргах ажлын
тендерийн баримт бичиг
ХОАОНӨГ/202001144*

Ховд хот

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.09.03

Хөвд аймгийн Дуут сумын засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Хөвд аймгийн Дуут сумын хөхбэлчир багт худаг гаргах ажил** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх **Дуут сумын эрүүл Хөхбэлчир багт худаг гаргах** ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн хамт 250000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Үнийн саналыг **2020 оны 09 дугаар сарын 14-ны өдрийн орон нутгийн цагаар 09 цаг 00, Улаанбаатар хотын цагаар 10 цаг 00 минут**-аас өмнө www.tender.gov.mn гэсэн хаягаар цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 09 дугаар сарын 14-ны өдрийн орон нутгийн цагаар 09 цаг 40 минут, Улаанбаатар хотын цагаар 10 цаг 40 минут**-д нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хөвд аймгийн Дуут сумын Засаг даргын тамгын
2-р давхарт “иргэний танхим” Утас: 89966660
Вэб: www.tender.gov.mn, E-mail: mandahichko5@gmail.com**

Хоёр.

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|--|--|
| <p>1. Эрх бүхий тендерт оролцогч</p> | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> |
| <p>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</p> | <p>2.1. Захиалагч тендеруудийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> |
| <p>3. Тендерийн иж бүрдэл</p> | <p>3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <p class="list-item-l1">(а) Үнийн санал;</p> <p class="list-item-l1">(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;</p> <p class="list-item-l1">(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</p> <p class="list-item-l1">(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</p> <p class="list-item-l1">(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</p> |
| <p>4. Тендерийн үнэ</p> | <p>4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.</p> <p>4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.</p> <p>4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтаасан үзнэ.</p> <p>4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.</p> |
| <p>5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</p> | <p>5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> |
| <p>6. Алдааг залруулах</p> | <p>6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:</p> <p class="list-item-l1">(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндийг зөв гэж үзнэ;</p> |

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. <i>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт</i> 2. <i>Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн акт/;</i> 3. <i>Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар</i> 4. <i>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар, хавсралт болон гэрээний хамт</i> 5. <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/</i> 6. <i>Харилцагч банкны тодорхойлолт /хугацаа хэтэрсэн зээлгүй байх/</i> 7. <i>Нийгмийн даатгалын тодорхойлолт /өргүй байх/</i> 8. <i>Татварын тодорхойлолт /өргүй байх/</i> 9. <i>Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар</i> 10. <i>Машин механизмын гэрчилгээ, тоног төхөөрөмжийн техникийн паспорт</i></p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Барилга хот байгуулалтын яамны тусгай зөвшөөрөл олгох суурь, нөхцөл шаардлагын 2.1.1, 2.2.1 заалт. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: Үйлчилгээний машин,автомрон 5тн,гагнуурын аппарат</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг www.tender.gov.mn Байгууллагын хаяг: Ховд аймгийн Дуут сумын Засаг даргын тамгын газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Ховд аймгийн Дуут сумын Босго баг Засаг даргын тамгын газар 2 давхар “иргэний танхим”</p> <p>Огноо: 2020 оны 09 дугаар сарын 02-ны өдөр Цаг: Орон нутгийн цагаар 09 цаг 00 минут, Улаанбаатар хотын цагаар 10 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Санхүүжилтүн эх үүсвэр: АХО 25 сая төгрөг Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: www.tender.gov.mn Байгууллагын хаяг: Ховд аймгийн Дуут сумын засаг даргын тамгын газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Ховд аймгийн Дуут сумын Босго баг Засаг даргын тамгын газар 2 давхарт “Иргэний танхитд”</p> <p>Огноо: 2020 оны 09 дугаар сарын 02-ны өдөр Цаг: Орон нутгийн цагаар 09 цаг 40 минут, Улаанбаатар хотын цагаар 10 цаг 40 минут</p>
ТОӨЗ 5.2	<p>Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10% хүртэл байна. Үүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерийн хамт ирүүлэх ба ТОӨЗ-нд дурдсан бусад шалгуурыг хангасан байна.</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй.</p>

Дөрөв. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
0	01 .Худаг гаргах ажил		
1	Цооног өрөмдөх цооногийг тоноглох		
1.1.	Геофизикийн судалгаа хийх , худгийн байршлыг эцэслэн тогтоох		
1.2.	Цооногийн ашиглалтын ундрага: 2m^3 - 6m^3 ус өгөх хүчин чадалтай байна.	m^3	180
1.3.	Худаг барих	m^2	3x3
2	Суултын яндангийн материал нь ган , ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	ш	1
3	Шүүрийн яндангийн материал нь ган , ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	ш	2
4	Ус өргөх яндангийн диаметр 25 мм –ээс доошгүй байна	м	25
5	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй , тоосонцор хольцгүй , мөхлөгийн хэмжээ 10-15мм-ээс томгүй байна	мм	20
6	Тунгаагуурын гүн 2 м-ээс багагүй	м	2
7	Худгийн шавхалт хийж цэвэрлэх хугацаа 24 цагаас багагүй	цаг	24
8	Усны чанарын сорил авч шинжилгээ хийлгэсэн байна.	ш	1
9	Худгийг түр хугацаагаар тагаар тоноглох	ш	1
10	Худгийн өрөмдлөгийн гүн 50м-ээс багагүй цооногтой байна.	м	50
11	Худгийн усан сан , мал услах онгоц , талбай барих		

12	Босоо суурьтай тоноглогдсон , гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,5м3-ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай	м	2
13	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь :60мм диаметртэй , гаднах ханаас 2 м урттай байхаар ган хоолойг бэхлэсэн байх	м	2
14	Үндны ус авах хоолой нь :32мм диамертэй ган хоолойг сонгох	мм	32
15	Мал уslaх онгоцны : -Хэмжээ 9м-ээс багагүй урттай 400мм-ийн голчтой хагас цилиндр -Материал: Ган хоолой буюу цутгамал бетон -Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2 м-ийн зайнд байрлуулна. -Онгоцны адагт ус юулэх жижиг нүх гаргана. -Усан сангаас мал уslaх онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолд шавхархаар байрлуулж гагнана.	м	2
16	Мал уslaх тайлбай : -Хэмжээ: -ний уртын дагуу 2 талдаа 2 м өргөнтэй , зузаан нь 10сm -Материал :150 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэж өгнө. -Уslaх тайлбай нь мал уslaх онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юулэгдэхэд тохиромжтой байна.	сm	10

17	Худгийн носос, бага оврын цахилгаан үүсгүүр , цахилгааны утас , хянах самбар		
18	Гүний насос :ISO9001 стандартын шаардлага хангасан , Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх. Үйлдвэрлэгчийн техникийн гэрчилгээ, зөвшөөрлийг хавсаргаж ирүүлнэ		
19	Цахилгааны утас:3 салаа , худаг ашиглах шаардлагыг хангасан насосоос хянах самбарт хүртэл үргэлжилсэн / залгаасгүй/ , ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно.	M	10
20	Бага оврын цахилгаан үүсгүүр :бензинээр ажилладаг /ISO стандартыг хангасан / Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх, техникийн үзүүлэлт , ашиглалтын зааврыг монгол хэлээр ирүүлнэ.		

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олго;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийг бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо.ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| <p>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</p> <p>2. Төслийн менежерийн шийдвэр</p> <p>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</p> <p>4. Аюулгүй байдал</p> <p>5. Зааварчилгаа</p> <p>6. Маргааныг шийдвэрлэх</p> <p>7. Ажлын хөтөлбөр</p> <p>8. Зөрчил, гологдол илрүүлэх</p> <p>9. Зөрчил, гологдол арилгах</p> | <p>1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.</p> <p>3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.</p> <p>4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p> <p>5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй</p> <p>6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</p> <p>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</p> <p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> <p>8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.</p> <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусхаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдолыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдолыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> |
|---|---|

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

10. Зөрчил, гологдол арилгахгүй байх	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардлагах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ	
11. Үе шатны ажлын хуваарь	11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
	11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх	12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. Алданги	13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ	
14. Ажил дуусгах	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо	16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
17. Ашиглалт, засвар,	17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

үйлчилгээний гарын авлага	<p>акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өтнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстай төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.</p>
18. Гэрээг цуцлах	<p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон; (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй; (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан; (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй; (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон. <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p>
19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр	<p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p> <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p>
20. Гүйцэтгэлээс чөлөөлөх	<p>20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон</p>

түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Ховд аймгийн Дуут сумын хөхбэлчир багийн худаг гаргах ажлын тендерийн баримт бичиг ХОАОНӨГ/202001144
ГЕН 2.1	Ажил нь [төвч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]-аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>Дуут сумын Босго багт байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.</i>
ГЕН 3.1	Төслийн менежер нь [томилогдсон этгээдийн нэр, хаяг]
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2020 оны 09 сарын 21 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020 оны 10 сарын 15
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 2 жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.5 байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 0,5 байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 2020.09.24 -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг 2020.09.24 -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ[мөнгөн дүн] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [хувь]-иартооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хүчилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;

- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
5.9. Санхүүжилтийн хуваарь;
5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зэрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]